

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2024/03/27

Дуусах хугацаа: 2024/04/27

Ажил эхлэх хугацаа: 2024/04

Цалин: Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН МЭРГЭЖИЛТЭН

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- Сургуулийн техник хангамжийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хангаж ажиллах;
- Сургуулийн нийт ажилтнуудад мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэх, ашиглах, суурилуулах, тохиргоо хийхтэй холбоотой ажлыг хариуцах;
- Сургуулийн мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх;
- Сургуулийн бусад шаардлагатай үйл ажиллагаанд оролцох, дэмжлэг үзүүлэх.

Тавигдах шаардлага:

- Мэдээллийн технологи, Мэдээллийн сүлжээ, Харилцаа холбоо, Компьютерын инженерийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх;
- Мэдээллийн технологийн чиглэлээр 2-оос дээш жил ажилласан туршлагатай байх;
- Англи хэлний B1 түвшний мэдлэгтэй байх;
- Mikrotik, Cisco routers болон Аналог, IP PBX – ийн тохиргоо хийдэг бол давуу тал болно.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар – CV
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа – 2 хувь

Холбоо барих:

Та баримт бичгээ англи, монгол хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж recruitment@gmit.edu.mn хаягаар бидэнд ирүүлнэ үү.

Цахим хуудас: www.gmit.edu.mn

Утас: +976-7023 2090

Жич: *Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.*